

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

2021 оны 12 дугаар сарын 14

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	“Уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуй, орон нутгийн онцлогт тохирсон дэвшилтэд технологи бүхий үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэн аймгийнхаа эдийн засгийн тогвортой өсөлтийг бий болгох” гэсэн зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Уг зорилт болон ХХААГ-ын стратеги хэтийн төлөвлөгөө, байгууллагын зохион байгуулалтын бүтцийг байгууллагын цахим хаягт ойлгомжтой байдлаар байршуулсан.	100
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Төрийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, СӨГ, захидал харилцааны асуудал хариуцсан мэргэжилтний эцэг /эх/-ийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь зэргийг цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.	100
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	ЖДҮ-ийн зээл авах сонирхолтой иргэд, Ноос арьс шир, ноолуурын урамшуулал авах малчид, мал бүхий иргэдийн бүрдүүлэх материалын мэдээллийг байршуулсан.	100
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	ХХААГ-т мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг байгууллагын сайт дээр байршуулсан бөгөөд тэдгээр нь www.legalinfo.mn хуулийн нэгдсэн портал сайттай холбогдсон болно. Нийт 38 хууль, Засгийн газрын 12 тогтоол байршуулсан.	100
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Тус байгууллага нь удирдлагын түвшинд Тушаал гаргадаг. Тушаалуудыг байгууллагын цахим сайтад байршуулдаг.	100
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Иргэдэд үзүүлж буй үйлчилгээнийхээ арга хэлбэрийг боловсронгуй болгохын тулд байгууллагаас иргэдэд үйлчлэх үйлчилгээний талаарх	100

		танилцуулга, ЖДҮ-тэй холбоотой асуудлаар хандаж буй иргэдэд шаардлагатай бичиг баримт зэрэг мэдээллийг байршуулсан.	
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх төсөвгүй тул drive.google.com прогарммыг ашиглан 15 сумын 60 малчнаар санал асуулаг явуулсан бөгөөд ХХААГ-ын ерөнхий үнэлгээ 90 хувьтай гарсан байна.	100
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	ХХААГазар нь зөвшөөрөл олгодоггүй.	-
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс санхүүжин хэрэгжсэн ажлууд /худаг, зоорь, агуулах, борлуулалтын цэг, мал угаалгын ванн/-ыг цаг тухай бүрт нь иргэд олон нийтэд байгууллагын цахим хуудас, фэйс хаягаар давтагдсан тоогоор 12 удаа хүргэж ажилласан.	100
Хэсгийн дундаж хувь:			100
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Мал үржлийн албаны сул 2 орон тооны захилгыг төрийн албаны салбар зөвлөлийн аймгийн салбар зөвлөлд газрын даргын 2021 оны 01/23 тоот албан бичгээр хүргэн ажилласан. Байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбар, төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд мэдээлсэн. МҮАлбаны 2 сул орон тоо хуулийн дагуу нөхөгдөж, томилогдон ажиллаж байна.	100
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Бүх төрийн албан хаагч нартай “Ёс зүйн дүрэм” гэрээ байгуулан дүгнэн ажиллаж байна.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт байршуулан ажилтан, албан хаагчид мөрдлөг болгон ашиглаж хэвшсэн. Ёс зүйн зөрчил гараагүй.	100

3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоол, журам, зааварыг үндэслэн Хүнс хөдөө аж ахуйн газрын хөгжлийн стратеги /хэтийн / төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгууллагын даргын 2021 оны А/14 тоот тушаалаар байгуулан, 2021-2024 он хүртэлх Дундговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэ стратеги төлөвлөгөөнд байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зарчим, стратегийн зорилт, хүрэх үр дүн, хамрах хүрээ, байгууллагын бүтэц, хүний нөөц, хяналт шинжилгээ гэх мэт асуудлуудыг тусгасан болно. Дээрх стратеги төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан, байгууллагын даргын 2018 оны А/18 тоот тушаалаар батлуулж хөтөлбөртэй уялдуулан 2021 оны жилийн төлөвлөгөө гарган, 98,8 хувьтай хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд тодорхой асуудлуудаар санал хүргүүлж 6 710 000 төгрөгийг шийдвэрлүүлэн ажиллаа. Мөн байгууллагынхаа вэб сайт болон мэдээлэлийн самбарт байршуулан иргэд олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.	100
4	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Хүний нөөцийн удирдлагад мэдээллийн технологийг өргөнөөр ашиглаж, төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан гаргах, ажлын байрны захиалга өгөх, нөөц бүрдүүлэх, нөөцийн санг ашиглах зэрэг арга ажиллагааг цахим хэлбэрээр явуулж байна.	100
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	ХХААГ-ын даргын 2021 оны 10 сарын 01 өдрийн А/22 тоот тушаалаар төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгох, төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журмыг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 40 дүгээр зүйлийн 40.4.2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагч нарт улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг олгож байна. 2021 онд	100

	төрийн захиргааны 2 албан хаагчид хуулийн дагуу ажилласан жилийн хугацааны нэмэгдэл, 5 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл, нийт албан хаагчдын цалингийн шатлалыг нэмэгдүүлэн төрийн үйлчилгээний 5 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг 15-25 хувиар олгож байна. 18.5 сая төгрөгийг зарцуулсан.	
Хэсгийн дундаж хувь:		100
Хэрэгжилтийн дундаж хувь:		100

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН: МЭРГЭЖИЛТЭН

И.ЖАМЪЯНМЯДАГ

ХЯНАСАН: ХХААГАЗРЫН ДАРГА

Б.МӨНХЖАРГАЛ